ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорнод аймгийн Засаг даргын Тамгын газын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код: ДОА-2025/126/НА-СТА-ТШЗ**

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Чойбалсан хот<br>2025 он | Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,<br>Тэргүүлэх аудитор: Б.Болортуул<br>Утас: 7058-4203, Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn<br>Аудитын менежер: И.Сэмжидмаа<br>Утас: 7058-4204, Цахим хаяг: semjidmaai@audit.gov.mn<br>Аудитор: М.Ухаанбилэг<br>Утас: 7058-4204, Цахим хаяг: ukhaanbilegm@audit.gov.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**АГУУЛГА**

1. Хараат бус аудиторын дүгнэлт....................................................................3-4

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл..........................................5-12

3. Аудитын илрүүлэлт ......................................................................................13

3.1 Төлбөрийн акт...........................................................................................13

3.2 Албан шаардлага.......................................................................................13

3.3 Зөвлөмж....................................................................................................14

4. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл.......................................................14

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| АДБОУС | Аудитын дээд байгууллагын Олон Улсын Стандарт |
| ДОА | Дорнод аймаг |
| ЗГ | Засгийн газар |
| ЗДТГ | Засаг даргын Тамгын газар |
| НББ | Нягтлан бодох бүртгэл |
| НА | Нийцлийн аудит |
| СС | Сангийн сайдын |
| СТА | Санхүүгийн тайлангийн аудит |
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |

## 1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

7 дугаар баг, Хэрлэн сум, Дорнод аймаг, 21000
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2025.02.24 № 297

танай___________-ны №____________-т

ДОРНОД АЙМГИЙН ЗАСАГ
ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГА П.БАТ-ӨЛЗИЙ ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорнод аймгийн Засаг даргын тамгын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй байна.

**Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

**Бусад асуудлын хэсэг**

Дорнод аймгийн Засаг даргын тамгын газар нь 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 5 зорилтын хүрээнд 81 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгаж, гүйцэтгэлийн тайланг аймгийн Засаг дарга 88.7 хувиар үнэлж, дүгнэсэн байна.

011022125

Өмнө жилийн санхүүгийн тайлангийн аудитаар тогтоосон төлбөрийн актыг шүүхийн байгууллагаас үндэслэлтэй гэж шийдвэрлэсэн ч аймгийн ЗДТГ нь шүүхийн шийдвэрийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч ажиллаагүй байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.БОЛОРТУУЛ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан /төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **325,440,320.00** | **349,036,984.00** |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 325,440,320.00 | 349,036,984.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 308,930,320.00 | 333,581,984.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 308,930,320.00 | 333,581,984.00 |
| 35600 | Мал амьтад | 16,510,000.00 | 15,455,000.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **10,533,138,332.50** | **10,425,191,545.19** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 10,533,138,332.50 | 10,425,191,545.19 |
| **392** | **Биет хөрөнгө** | 10,033,138,332.50 | 9,925,191,545.19 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 9,600,311,800.00 | 9,600,311,800.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (457,182,119.77) | (829,929,039.01) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 316,070,000.00 | 646,069,500.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (29,880,208.25) | (81,697,687.37) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 755,368,205.37 | 942,126,166.37 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (331,732,748.68) | (503,675,944.42) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 296,187,597.00 | 329,717,629.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (116,004,193.17) | (177,730,879.38) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 26,656,850.00 | 26,656,850.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (26,656,850.00) | (26,656,850.00) |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 500,000,000.00 | 500,000,000.00 |
| 39301 | Програм хангамж | 121,859,618.94 | 121,859,618.94 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (121,859,618.94) | (121,859,618.94) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 500,000,000.00 | 500,000,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **10,858,578,652.50** | **10,774,228,529.19** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **0.00** | **0.00** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 0.00 | 0.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **10,858,578,652.50** | **10,774,228,529.19** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 10,858,578,652.50 | 10,774,228,529.19 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 2,124,330,743.83 | 2,124,330,743.83 |
| 51101 | Өмч: - төрийн | 2,124,330,743.83 | 2,124,330,743.83 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 8,714,403,546.47 | 8,630,053,423.16 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 5,945,440,405.04 | 8,714,403,546.47 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 2,768,963,141.43 | (84,350,123.31) |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 19,844,362.20 | 19,844,362.20 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **10,858,578,652.50** | **10,774,228,529.19** |

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан /төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 16,966,179,335.53 | 7,722,061,738.10 |
| 11 | ТАТВАРЫН ОРЛОГО | - | - |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 10,956,004,138.53 | 593,224,411.10 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 10,956,004,138.53 | 593,224,411.10 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 31,097,775.00 | 40,300,918.10 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 31,097,775.00 | 40,300,918.10 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | 10,727,511,280.03 | 534,893,493.00 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал | 197,395,083.50 | 18,030,000.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 6,010,175,197.00 | 7,128,837,327.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 667,614,797.00 | 737,277,827.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 283,452,993.00 | 260,663,200.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 384,161,804.00 | 457,033,942.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | - | 19,580,685.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 5,342,560,400.00 | 6,391,559,500.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 4,829,776,200.00 | 4,917,299,500.00 |
| 132002 | Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгийн санхүүжилт | 512,784,200.00 | 1,474,260,000.00 |
| 2 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 14,197,216,194.10 | 7,806,411,861.41 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 14,197,216,194.10 | 7,806,411,861.41 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 12,162,446,600.53 | 7,170,316,914.06 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 1,859,629,282.80 | 2,939,731,637.60 |
| 210101 | Үндсэн цалин | 747,787,138.98 | 1,179,593,407.31 |
| 210102 | Нэмэгдэл | 484,344,588.13 | 850,401,712.06 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 47,720,842.62 | 51,001,699.09 |
| 210104 | Урамшуулал | 62,565,729.28 | 152,657,596.35 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 517,210,983.79 | 706,077,222.79 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 230,116,617.85 | 347,225,709.06 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 156,345,974.02 | 237,026,468.44 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 18,971,299.23 | 27,517,094.30 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 15,176,999.80 | 13,723,608.80 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 3,355,580.59 | 13,091,314.08 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 36,266,764.21 | 55,867,223.44 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 90,659,462.65 | 145,803,354.98 |

| | | | |
|---|---|---|---|
| 210301 | Гэрэл, цахилгаан | 20,125,350.89 | 37,540,021.87 |
| 210302 | Түлш, халаалт | 38,829,533.56 | 65,823,357.11 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 14,704,578.20 | 25,439,976.00 |
| 210304 | Байрны түрээс | 17,000,000.00 | 17,000,000.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 237,861,535.73 | 282,866,713.61 |
| 210401 | Бичиг хэрэг | 49,799,695.00 | 58,847,500.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 69,891,600.00 | 94,033,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 12,633,465.13 | 11,268,533.61 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 65,227,210.00 | 68,500,000.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 40,309,565.60 | 50,217,680.00 |
| 2105 | Нормативт зардал | 1,500,000.00 | 31,467,000.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,500,000.00 | 31,467,000.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 45,068,020.00 | 95,016,590.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 2,958,500.00 | 23,487,800.00 |
| 210604 | Урсгал засвар | 42,109,520.00 | 71,528,790.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 95,500,400.00 | 143,625,800.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 95,500,400.00 | 143,625,800.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 157,733,765.00 | 599,400,623.50 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 141,909,900.00 | 575,661,968.30 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 11,596,525.00 | 21,734,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 49,340.00 | 181,676.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,378,000.00 | 1,386,064.00 |
| 210807 | Газрын төлбөр | 2,800,000.00 | 436,915.20 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 9,444,377,516.50 | 2,585,179,485.31 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 9,208,260,226.50 | 1,895,438,889.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 50,442,550.00 | 31,506,316.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 185,674,740.00 | 658,234,280.31 |
| 211 | ХҮҮ | 1,858,364,600.00 | 224,750,000.00 |
| 2112 | Дотоод зээлийн үйлчилгээний төлбөр | 1,858,364,600.00 | 224,750,000.00 |
| 211201 | Дотоод зээлийн үйлчилгээний төлбөр | 1,858,364,600.00 | 224,750,000.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 176,404,993.57 | 411,344,947.35 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 11,155,000.00 | 242,112,242.42 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 11,155,000.00 | 13,464,000.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | - | 32,149,318.94 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | - | 196,498,923.48 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 163,913,474.96 | 160,192,061.01 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 163,913,474.96 | 160,192,061.01 |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 1,336,518.61 | 9,040,643.92 |

| | | | |
|---|---|---|---|
| 213405 | Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг | 1,336,518.61 | 9,040,643.92 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2) | 2,768,963,141.43 | (84,350,123.31) |
| 5 | НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4) | 2,768,963,141.43 | (84,350,123.31) |

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан** **/төгрөгөөр/**

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | | |
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1) | 6,041,272,972.00 | 7,169,138,245.10 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 31,097,775.00 | 40,300,918.10 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 31,097,775.00 | 40,300,918.10 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 31,097,775.00 | 40,300,918.10 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 31,097,775.00 | 40,300,918.10 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 6,010,175,197.00 | 7,128,837,327.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 667,614,797.00 | 737,277,827.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 283,452,993.00 | 260,663,200.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 384,161,804.00 | 457,033,942.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | - | 19,580,685.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 5,342,560,400.00 | 6,391,559,500.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 4,829,776,200.00 | 4,917,299,500.00 |
| 132002 | Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгийн санхүүжилт | 512,784,200.00 | 1,474,260,000.00 |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2) | 6,041,272,972.00 | 7,169,138,245.10 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 6,041,272,972.00 | 7,169,138,245.10 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 4,006,503,378.43 | 6,533,043,297.75 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 1,859,629,282.80 | 2,939,731,637.60 |
| 210101 | Үндсэн цалин | 747,787,138.98 | 1,179,593,407.31 |
| 210102 | Нэмэгдэл | 484,344,588.13 | 850,401,712.06 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 47,720,842.62 | 51,001,699.09 |
| 210104 | Урамшуулал | 62,565,729.28 | 152,657,596.35 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 517,210,983.79 | 706,077,222.79 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 230,116,617.85 | 347,225,709.06 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 156,345,974.02 | 237,026,468.44 |

| | | | |
|---|---|---|---|
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 18,971,299.23 | 27,517,094.30 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 15,176,999.80 | 13,723,608.80 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 3,355,580.59 | 13,091,314.08 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 36,266,764.21 | 55,867,223.44 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 90,659,462.65 | 145,803,354.98 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 20,125,350.89 | 37,540,021.87 |
| 210302 | Түлш, халаалт | 38,829,533.56 | 65,823,357.11 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 14,704,578.20 | 25,439,976.00 |
| 210304 | Байрны түрээс | 17,000,000.00 | 17,000,000.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 191,066,070.13 | 228,301,533.61 |
| 210401 | Бичиг хэрэг | 49,799,695.00 | 54,500,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 69,891,600.00 | 94,033,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 12,633,465.13 | 11,268,533.61 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 58,741,310.00 | 68,500,000.00 |
| 2105 | Нормативт зардал | 1,500,000.00 | 31,467,000.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,500,000.00 | 31,467,000.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 67,251,820.00 | 139,324,990.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 23,796,400.00 | 54,525,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 43,455,420.00 | 84,799,990.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 95,500,400.00 | 143,625,800.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 95,500,400.00 | 143,625,800.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 200,369,815.00 | 636,494,523.50 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 184,545,950.00 | 612,755,868.30 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 11,596,525.00 | 21,734,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 49,340.00 | 181,676.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,378,000.00 | 1,386,064.00 |
| 210807 | Газрын төлбөр | 2,800,000.00 | 436,915.20 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 1,270,409,910.00 | 1,921,068,749.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 1,219,967,360.00 | 1,885,078,933.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 50,442,550.00 | 35,989,816.00 |
| 211 | ХҮҮ | 1,858,364,600.00 | 224,750,000.00 |
| 2112 | Дотоод зээлийн үйлчилгээний төлбөр | 1,858,364,600.00 | 224,750,000.00 |
| 211201 | Дотоод зээлийн үйлчилгээний төлбөр | 1,858,364,600.00 | 224,750,000.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 176,404,993.57 | 411,344,947.35 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 11,155,000.00 | 242,112,242.42 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 11,155,000.00 | 13,464,000.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | - | 32,149,318.94 |

| | | | |
|---|---|---|---|
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | - | 196,498,923.48 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 163,913,474.96 | 160,192,061.01 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 163,913,474.96 | 160,192,061.01 |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг | 1,336,518.61 | 9,040,643.92 |
| 213405 | Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг | 1,336,518.61 | 9,040,643.92 |
| 8 | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7) | - | - |
| 9 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | |
| 10 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан /төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Бусад | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|---|
| C01 | **2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | 2,124,330,743.83 | 19,844,362.20 | 5,945,440,405.04 | - | 8,089,615,511.07 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | - | - |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **2,124,330,743.83** | **19,844,362.20** | **5,945,440,405.04** | - | 8,089,615,511.07 |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт | - | - | - | - | - |
| C05 | Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт | - | - | - | - | - |
| C06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | - | - | - | - | - |
| C07 | Тайлант үеийн үр дүн | - | - | 2,768,963,141.43 | - | 2,768,963,141.43 |
| C08 | **2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **2,124,330,743.83** | **19,844,362.20** | **8,714,403,546.47** | - | 10,858,578,652.50 |
| D01 | **2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **2,124,330,743.83** | **19,844,362.20** | **8,714,403,546.47** | - | 10,858,578,652.50 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | - | - |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **2,124,330,743.83** | **19,844,362.20** | **8,714,403,546.47** | - | 10,858,578,652.50 |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | - | - | - | - | - |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | - | - | - | - | - |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | - | - | - | - | - |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | | | | | - |
| D08 | Тайлант үеийн үр дүн | - | - | (84,350,123.31) | - | (84,350,123.31) |
| D09 | **2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **2,124,330,743.83** | **19,844,362.20** | **8,630,053,423.16** | - | 10,774,228,529.19 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан /төгрөгөөр/

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **6,411,559,500** | **6,368,383,028** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **6,411,559,500** | **6,368,383,028** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 5,933,307,300 | 5,804,806,115 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 2,931,249,500 | 2,916,665,516 |
| 210101 | Үндсэн цалин | 1,178,000,000 | 1,179,593,407 |
| 210102 | Нэмэгдэл | 788,000,000 | 850,401,712 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 86,400,000 | 51,001,699 |
| 210104 | Урамшуулал | 182,782,800 | 152,657,596 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 696,066,700 | 683,011,101 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 368,226,100 | 344,446,533 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 250,367,500 | 234,239,397 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 29,464,700 | 27,524,989 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 14,732,300 | 13,723,609 |

| | | | |
|---|---|---|---|
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 14,732,300 | 13,091,314 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 58,929,300 | 55,867,223 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 155,000,000 | 145,803,355 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 42,000,000 | 37,540,022 |
| 210302 | Түлш, халаалт | 63,000,000 | 65,823,357 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 30,000,000 | 25,439,976 |
| 210304 | Байрны түрээс | 20,000,000 | 17,000,000 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 233,533,000 | 228,301,534 |
| 210401 | Бичиг хэрэг | 54,500,000 | 54,500,000 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 94,033,000 | 94,033,000 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 16,500,000 | 11,268,534 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 68,500,000 | 68,500,000 |
| **2105** | **Нормативт зардал** | 31,467,000 | 31,467,000 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 31,467,000 | 31,467,000 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 139,325,000 | 139,324,990 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 54,525,000 | 54,525,000 |
| 210604 | Урсгал засвар | 84,800,000 | 84,799,990 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 145,500,000 | 143,625,800 |
| 210702 | Дотоод албан томилолт | 145,500,000 | 143,625,800 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 222,334,000 | 219,730,655 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 196,000,000 | 195,991,999 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 21,734,000 | 21,734,000 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 400,000 | 181,676 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 400,000 | - |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 2,000,000 | 1,386,064 |
| 210807 | Газрын төлбөр | 1,800,000 | 436,915 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 1,706,672,700 | 1,635,440,733 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 1,677,052,700 | 1,605,820,733 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 29,620,000 | 29,620,000 |
| **211** | **ХҮҮ** | 224,750,000 | 224,750,000 |
| **2112** | **Дотоод зээлийн үйлчилгээний төлбөр** | 224,750,000 | 224,750,000 |
| 211201 | Дотоод зээлийн үйлчилгээний төлбөр | 224,750,000 | 224,750,000 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 253,502,200 | 338,826,913 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 253,502,200 | 242,112,242 |
| 213204 | Ажил олгогчоос олгох  бусад тэтгэмж, урамшуулал | 19,800,000 | 13,464,000 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 35,616,200 | 32,149,319 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 198,086,000 | 196,498,923 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **6,411,559,500** | **6,368,383,028** |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **6,391,559,500** | **6,328,082,110** |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 6,391,559,500 | 6,328,082,110 |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | 20,000,000 | 40,300,918 |
| **4** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | - | - |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | | |
| **61** | **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | - | - |
| **65** | **ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ** | **95** | **95** |
| 650001 | Төрийн захиргааны албан хаагч (ТЗ) | 48 | 48 |
| 650002 | Төрийн тусгай албан хаагч (ТТ) | 4 | 4 |
| 650007 | Мэргэжлийн боловсролын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮМБ) | 7 | 7 |

| | | | |
|---|---|---|---|
| 650009 | Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ) | 29 | 29 |
| 650010 | Гэрээт ажилтан | 2 | 2 |
| 650011 | Улс төрийн албан хаагч (УТ) | 5 | 5 |

**2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан** **/төгрөгөөр/**

| **Дансны код** | **Үзүүлэлт** | **Гүйцэтгэл** |
|---|---|---|
| | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | |
| I | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **728,237,183.08** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **728,237,183.08** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 728,237,183.08 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 23,066,121.91 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 23,066,121.91 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 2,779,176.17 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 2,779,176.17 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 418,763,869.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 418,763,869.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 283,628,016.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 277,258,200.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 6,369,816.00 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **728,237,183.08** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **728,237,183.08** |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 251,622,556.08 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 457,033,942.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 19,580,685.00 |
| **IV** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)** | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | |

## 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар залруулга хийгдээгүй болно.

Аудитаар нийт 195,887.4 мянган төгрөгийн зөрчил[1] илэрснээс, 122,405.6 мянган төгрөгийн алдаа зөрчлийг таслан зогсоох албан шаардлага, 73,481.7 мянган төгрөгийн 2 зөвлөмж өгөв.

### 3.1 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоогдоогүй болно.

### 3.2 Албан шаардлага

1. Өнгөрсөн оны санхүүгийн тайлангийн аудитаар тогтоосон 09 ДОА-2024/93/НА-СТА-ТШЗ А1170309 дугаартай 56,463.6 мянган төгрөгийн төлбөрийн акт, 19 ДОА-2024/93/НА-СТА-ТШЗ А1170309 дугаартай албан шаардлагыг шүүхийн байгууллагаас үндэслэлтэй гэж шийдвэрлэсэн ч шүүхийн шийдвэрийн биелэлтийг хангуулж ажиллаагүй тухайд аймгийн Засаг даргын тамгын газраас 2025.02.21-ний өдрийн 2/416 дугаартай албан бичгийн хавсралтаар ирүүлсэн тайлбарт “шүүхийн эцсийн шийдвэр 2024 оны дөрөвдүгээр улиралд гарсан тул төлбөрийн актыг барагдуулах асуудал хойшлогдсон, үйлчилгээний албан хаагчдын амьжиргаанд хүндрэл үүсгэхгүйн тулд цалингаас суутгах төлбөрийн хэмжээг хэмжээг жилийн хугацаанд тэгш хуваан 2025 ондоо барагдуулахаар тооцож ажиллаж байна.” гэсэн тайлбарыг үндэслэлтэй гэж үзэж хариуцлага тооцуулах албан шаардлагыг зөрчил арилгах албан шаардлага болгон өөрчилж, төлбөрийн актын биелэлтийг 2025 оны 6 дугаар сарын 25-ны өдрийн дотор барагдуулах албан шаардлага хүргүүлж байна.

2. Дорнод аймгийн Засаг даргын тамгын газрын зарим албан хаагчид ажлын зайлшгүй шаардлагаар гэх үндэслэлээр удаа дараа ээлжийн амралтыг биеэр эдлэхгүй, Хөдөлмөрийн тухай хуулийн 110 дугаар зүйлийн 110.2-т заасныг үндэслэн ээлжийн амралтын цалинг 1.5 дахин нэмэгдүүлэн 61.3 сая төгрөгийг тооцуулж авсан байна. Энэ нь Төрийн албаны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.4-т “Төрийн албан хаагчийн хөдөлмөрийн харилцаатай холбоотой энэ хуулиар зохицуулаагүй бусад асуудлыг Хөдөлмөрийн тухай болон бусад хуулиар зохицуулна.” гэсэн заалтыг зөрчсөн, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.3-т "хэрэгжүүлэх аливаа үйл ажиллагаа, арга хэмжээ нь хамгийн бага зардлаар хамгийн өндөр үр дүнг хангахад чиглэсэн байх;" гэсэн зарчимтай нийцэхгүй, мөн хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.6-д "байгууллагын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, цалин хөлсийг орлого, гүйцэтгэл, үр дүн, үр ашигтай нь уялдуулан олгох.” гэсэн заалтыг мөрдөж ажиллаагүй, төсвийн хэмнэлттэй ажиллахад анхаарч хүний нөөцөө оновчтой хуваарилж ажиллаагүй нь санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3. Аймгийн Засаг даргын тамгын газрын даргын 2024 оны Б/86 дугаар урамшуулал олгох тухай тушаалаар Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны санхүүгийн тайлан, тэнцэл, төсвийн гүйцэтгэл, аймгийн санхүүгийн нэгдсэн тайланг Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу хуулийн хугацаанд чанартай бүрэн гарган Сангийн яаманд нэгтгүүлж, үр дүнтэй ажилласан Төсвийн ерөнхий нягтлан бодогч, аймгийн Засаг даргын тамгын газрын нягтлан бодогч нарыг 4,602.0 мянган төгрөгийн мөнгөн шагналаар шагнаж урамшуулсан байна. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3-т "хууль тогтоомжид заасанаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох;" гэсэн заалтыг зөрчсөн, ЗГ-ын 2019 оны 05 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 2.2-т "Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь

[1] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 50 хувиас хэтрэхгүй байна." гэсэн заалтыг зөрчин урамшууллын хувь хэмжээнээс хэтрүүлж, давхардуулан олгосон нь санхүүгийн тайлангийн аудитын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

### 3.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1.Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал

*Илрүүлэлт:* Аймгийн Засаг даргын тамгын газрын үндсэн хөрөнгөд 2022 оноос эхлэн бүртгэлтэй 58.2 сая төгрөгийн зарим хөрөнгүүдийг аймгийн Татварын газар, Зэвсэгт хүчний 327 дугаар анги, 13 сумдын Ахмадын хороод ашиглаж байна. Эдгээр хөрөнгөнд бодит тооллого хийсэн нь нотлогдохгүй байгаа тул Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2.1-т “жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө;” гэсэн заалтыг хэр Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 4-т “Тооллогын комисс дараахь үүрэгтэй: 1/ эд хөрөнгийн тооллогыг тогтоосон хугацаанд үнэн зөв, чанартай явуулж дуусгах;” гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй, санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*Өгсөн зөвлөмж:* Хөрөнгийн тооллогыг үнэн зөв, чанартай хийж гүйцэтгэж ажиллах.

2.Хэвлэл мэдээллийн байгууллагуудтай байгуулсан гэрээтэй холбоотой асуудал

*Илрүүлэлт:* Аймгийн Засаг даргын тамгын газар нь тайлант онд хэвлэл мэдээллийн чиглэлээр Улаанбаатар хотын Ган үзэгтэн ХХК, Улаанбаатар телевиз ХХК, Эрхэт монгол групп ХХК-уудтай гэрээ байгуулж ажиллахдаа гэрээний биелэлтийг дүгнэж ажиллаагүй, хэзээ хэчнээн мэдээ өгч нийтлүүлсэн нь тодорхойгүй байна.

Өгсөн зөвлөмж: Гэрээний биелэлтийг дүгнэж ажиллах.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д заасны дагуу “Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ”. Харин зөвлөмжийн биелэлтийг 2025 оны 5 дугаар сарын 20 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - |
| Дүн | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - |

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Хариуцлага тооцуулах албан шаардлага | 1 | 56,463.6 | - | - | 1 | 56,463.6 | - | - | - | - | - | - |
| Ээлжийн амралт эдлээгүй, Төрийн албаны хуулийн 4.4-ийг зөрчсөн | 1 | 61,340.0 | - | - | 1 | 61,340.0 | - | - | - | - | - | - |
| Урамшуулал давхардуулан авсан | 1 | 4,602.0 | - | - | 1 | 4,602.0 | - | - | - | - | - | - |
| Хөрөнгөнд тавих хяналт сул | 1 | 58,181.7 | - | - | - | - | 1 | 58,181.7 | - | - | - | - |
| Хэвлэлийн байгууллагуудтай хийсэн гэрээний биелэлтийг дүгнээгүй | 1 | 15,300.0 | - | - | - | - | 1 | 15,300.0 | - | - | - | - |
| Дүн | 5 | 195,887.4 | - | - | 3 | 122,405.6 | 2 | 73,481.7 | - | - | - | - |

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| | | | | | | | | |
| Дүн | - | - | - | - | - | - | - | - |
| Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой | | | | | | | | |
| - | - | - | - | - | - | - | - | - |
| Дүн | - | - | - | - | - | - | - | - |
| Бусад хууль тогтоомжтой холбоотой | | | | | | | | |
| - | - | - | - | - | - | - | - | - |
| Нийт дүн | - | - | - | - | - | - | - | - |

ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 02 сарын 25 өдөр Дугаар 60 ДОА-2025/126/НА-СТА-ТШЗ А1170309 Чойбалсан хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1-т заасны дагуу Дорнод аймгийн Засаг даргын тамгын газрын 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Өнгөрсөн жилийн санхүүгийн тайлангийн аудитаар тогтоосон төлбөрийн 09 ДОА-2024/93/НА-СТА-ТШЗ А1170309 дугаартай төлбөрийн акт, 09 ДОА-2024/93/НА-СТА-ТШЗ А1170309 дугаартай албан шаардлагыг Монгол Улсын Дээд шүүхийн захиргааны хэргийн танхимын нийт шүүгчийн хуралдааны 2024 оны 11 сарын 12-ны өдрийн тогтоолоор Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн магадлалд гаргасан хяналтын гомдлыг хэлэлцэхээс татгалзаж давж заалдах шатны шүүхийн магадлалаар үндэслэлтэй гэсэн шийдвэр хүчин төгөлдөр болсон. Дорнод аймгийн Засаг даргын тамгын газар нь шүүхийн шийдвэрийг биелүүлэх арга хэмжээ авч ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.11-т “хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал;” гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Дорнод аймгийн Засаг даргын тамгын газар нь шүүхийн шийдвэрээр хүчин төгөлдөр болсон төлбөрийн актын үлдэгдлийг барагдуулж, биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 25-ны дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Дорнод аймгийн Засаг даргын тамгын газрын дарга П.Бат-Өлзий, нягтлан бодогч П.Чимигсүрэн нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН МЕНЕЖЕР П.СЭМЖИДМАА

АУДИТОР М.УХААНБИЛЭГ

2125040103

ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 02 сарын 25 өдөр Дугаар 61 ДОА-2025/128/НА-СТА-ТНЗ 11170309 Чойбалсан хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1-т заасны дагуу Дорнод аймгийн Засаг даргын тамгын газрын 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Дорнод аймгийн Засаг даргын тамгын газрын зарим албан хаагчдад ажлын зайлшгүй шаардлагаар гэх үндэслэлээр ээлжийн амралтыг биеэр эдлүүлэхгүй, Хөдөлмөрийн тухай хуулийн 110 дугаар зүйлийн 110.2-т заасныг үндэслэн ээлжийн амралтын цалинг 1.5 дахин нэмэгдүүлэн 61.3 сая төгрөгийг олгосон байна.

Энэ нь Төрийн албаны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.4-т "*Төрийн албан хаагчийн хөдөлмөрийн харилцаатай холбоотой энэ хуулиар зохицуулаагүй бусад асуудлыг Хөдөлмөрийн тухай болон бусад хуулиар зохицуулна.*", 61 дүгээр зүйлийн 61.1.9-т "*ажлын зайлшгүй шаардлагаар ээлжийн амралтаа биеэр эдэлж чадаагүй төрийн захиргааны албан хаагчид түүний зөвшөөрснөөр 1.5 сарын албан тушаалын цалинтай тэнцэх мөнгөн урамшуулал олгох;*" гэсэн заалтыг зөрчсөн, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.3-т "*хэрэгжүүлэх аливаа үйл ажиллагаа, арга хэмжээ нь хамгийн бага зардлаар хамгийн өндөр үр дүнг хангахад чиглэсэн байх*; гэсэн зарчимтай нийцэхгүй, мөн хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.6-д "*байгууллагын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, цалин хөлсийг орлого, гүйцэтгэл, үр дүн, үр ашигтай нь уялдуулан олгох.*" гэсэн заалтыг мөрдөж ажиллаагүй, төсвийг хэмнэлттэй ажиллахад анхаарч, хүний нөөцөө оновчтой хуваарилж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал;" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Дорнод аймгийн Засаг даргын тамгын газар нь зарим албан хаагчдад ээлжийн амралтыг биеэр эдлүүлээгүй, ээлжийн амралтын цалинг 1.5 дахин нэмэгдүүлэн тооцож олгосон 61,340,075.0 /жаран нэгэн сая гурван зуун дөчин мянга далан тав/ төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй, албан хаагчдын ээлжийн амралтыг биеэр эдлүүлэх, Төрийн албаны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.4, 61.1.9-т заасныг мөрдөж ажиллах, биелэлтийг 2025 оны 6 дугаар сарын 20-ны дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх;

2125040106

2. Цаашид дээрх зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Дорнод аймгийн Засаг даргын тамгын газрын дарга П.Бат-Өлзий, нягтлан бодогч П.Чимигсүрэн нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН МЕНЕЖЕР И.СЭМЖИДМАА

АУДИТОР М.УХААНБИЛЭГ

ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 02 сарын 25 өдөр Дугаар 62 20А-2025/126/ИА-СТА-ТШ3 А1170309 Чойбалсан хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1-т заасны дагуу Дорнод аймгийн Засаг даргын тамгын газрын 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Дорнод аймгийн төсвийн ерөнхий нягтлан бодогч болон аймгийн Засаг даргын тамгын газрын нягтлан бодогч нарт жилийн эцсийн үр дүнгийн мөнгөн урамшууллаас гадна санхүүгийн тайланг Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу хуулийн хугацаанд чанартай бүрэн гарган Сангийн яаманд нэгтгүүлсэн, үр дүнтэй ажилласан үндэслэлээр үр дүнгийн урамшууллыг олгосон байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3-т *"хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох;"*, Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журмын 2.2-т *"Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 50 хувиас хэтрэхгүй байна."* гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал;" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Урамшууллыг давхардуулан олгосон 4,602,000 /дөрвөн сая зургаан зуун хоёр мянга/ төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй, ЗГ-ын 2019 оны 05 дугаар тогтоолын гуравдугаар хавсралтаар батлагдсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 2.2-т заасныг мөрдөж ажиллах, биелэлтийг 2025 оны 6 дугаар сарын 20-ны дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх;

2125040109

2. Цаашид дээрх зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Дорнод аймгийн Засаг даргын тамгын газрын дарга П.Бат-Өлзий, нягтлан бодогч П.Чимигсүрэн нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН МЕНЕЖЕР И.СЭМЖИДМАА

АУДИТОР М.УХААНБИЛЭГ

2117144066
ХТҮ4037 9030891